

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны
2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн
03/29 дугаартай албан бичгийн хавсралт



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (2024-2030)-Д ТУССАН
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Д/д	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Санхүүжилт, эх үүсвэр /шаардлагатай хөрөнгийн хэмжээ (сая төгрөгөөр)/	Хэрэгжилт	Хувиар
ҮНДСЭН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ							
1	2.5.1.Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2.5.1.1.Төрөөс хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үзүүлэх үйлчилгээний тоог нэмэгдүүлэх	Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээний тоо	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (www.e-mongolia.mn)-д 2022 онд 69 байгууллагын 897 үйлчилгээг, 2023 онд 86 байгууллагын 1170 үйлчилгээг тус тус холбож, цахим хэлбэрээр үзүүлж байна.	779.7	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (www.e-mongolia.mn)-д 2024 онд 97 үйлчилгээ шинээр нэмэгдэж нийт 87 байгууллагын 1263 үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр хүргэж байна. Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн "e-Mongolia 4.0" хувилбарыг 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдөр ашиглалтад оруулсан бөгөөд энэхүү хувилбарын хүрээнд дараах өөрчлөлт, шинэчлэлүүд системд нэмэгдсэн: • тээврийн хэрэгсэл, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө эзэмшиж буй аж ахуйн нэгжийн бүхий л мэдээллийг профайл хэсэгт байршуулсан; • сонирхсон үйлчилгээг дуу хоолой ашиглан хайх боломжийг Чимэгэ системс ХХК-тай хамтран бүрдүүлсэн; • замын хураамж, тээврийн болон жолоочийн торгууль, үер ус, угаарын хийн мэдрэгчийн мэдээллийг хүргэдэг болсон; • эрүүл мэндийн цахим шилжилттэй холбогдуулан 7 үйлчилгээг шинээр нэмсэн; • иргэн өөрийн дархлаажуулалтад хамрагдсан талаарх мэдээллийг хянах хэсгийг нэмсэн; • иргэн уг системд нэвтэрсэн түүх, бүртгэлтэй төхөөрөмжийн мэдээллийг "хандалтууд" хэсгээс хугацааны талаарх мэдээллийн хамт харах боломж бүрдсэн; • Ekids цэсэд нас насны ангилалд тохирсон "Хүрээлэл" цэсийг хөгжүүлсэн; • "E-mongolia chat"-ийг Нэкст Сошиал Платформ Провайдер ХХК /МонголНет/-тай хамтран хөгжүүлж, системийн хэрэглэгчид хоорондоо чатаар харилцах боломжийг аппликэйшн болон веб сувгийн хувилбартай үүсгэсэн; • "Малчин" цэсийг шинээр ашиглалтад оруулж, өмнө нь тусдаа байсан мал тооллогын лавлагаа, малчны тодорхойлолт, мал бүхий иргэний тодорхойлолт зэрэг үйлчилгээг нэг дор харуулдаг болсон.	100

					• 2024 онд сонгуульд санал өгсөн байршлын мэдээллийн иргэд нээлттэй харах боломж бүрдүүлсэн. • Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар, Хуулийн этгээдийн цахим гэрчилгээний хуулбар зэргийг профайл цэсээс харж ашиглах боломжтой болсон. Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлснээр нийт 1,337,926,023,905 төгрөгийн зардлыг хэмнэснээс 2024 онд 511,763,050,750 төгрөгийн зардлыг хэмнэсэн байна.		
2	2.5.3.Төрийн байгууллагын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг үе шаттайгаар бүрэн цахимжуулна.	2.5.3.1.Төрийн байгууллагын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг үе шаттайгаар бүрэн цахимжуулах	Цахимаар олгож буй зөвшөөрлийн тоо	Цахим хэлбэрээр 2023 оны байдлаар нийт 66 зөвшөөрлийг олгож байна.	0	Засгийн газрын 2023 оны 233 дугаар тогтоолоор Зөвшөөрлийн тухай хуульд заасан зөвшөөрлийг цахим хэлбэрээр шийдвэрлэх харилцааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх арга хэмжээ авч, тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэр гаргах үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбох арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ, И-Монгол академи УТҮГ-т тус тус даалгасан. Тус ажлын хүрээнд И-Монгол академи үйлчилгээний судалгааг хийх, цаашид үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг хариуцаж, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв хөгжүүлэлтийн ажлыг хариуцахаар шийдвэрлэсэн. Мөн ажлын хүрээнд уулзалтыг зохион байгуулж үйлчилгээний судалгаа, бодлогын даалгаврын загварыг эцэслэн тохирсон. Зөвшөөрлийн тухай хуульд тусгагдсан нийт 252 тусгай зөвшөөрөл байгаагаас зөвшөөрөл олгогч эрх бүхий байгууллагын хөгжүүлсэн өөрийн цахим системтэй 139 зөвшөөрөл, хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулийн хүрээнд цахимаар олгох боломжгүй 19 зөвшөөрөл байна. И-Монгол академи УТҮГ болон Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв хамтран 2024 онд 94 зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлснээс https://license.mn/ системд 51 зөвшөөрлийг, https://e-business.mn/main-services системд 43 зөвшөөрлийг тус тус байршуулсан. Мөн Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа Ухаалаг засаг 2 төслийн хүрээнд “2.1.3.1.Цахим зөвшөөрлийн систем” төслийг зарлан холбогдох ажлын даалгаврыг боловсруулах гүйцэтгэгчийг шалгаруулах ажиллагаа хийгдэж байна.	100
3	3.2.4.Нийтийн мэдээллийг нээлттэй өгөгдлийн стандартын дагуу ил болгож, иргэн шууд хяналт тавих	3.2.4.1.Нийтийн мэдээллийг нээлттэй өгөгдлийн стандартын дагуу ил болгосон эсэхэд дүн шинжилгээ хийх	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тоо	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу байнга нээлттэй, ил тод байлгах 68 төрийн мэдээллийг байршуулах талаар холбогдох	0	Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолоор 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарлаж, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 48 дугаар захирамжаар авлигатай тэмцэх “Шил ажиллагаа”-ны хэрэгжилтийг хариуцан зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдад даалгасан. Шил ажиллагааны хүрээнд цахим шилжилтийг эрчимжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хүнд суртлыг арилгах зорилгоор www.shilen.gov.mn системийг 2023 оны 3 дугаар	30

	боломжийг бүрдүүлнэ.			байгууллагад тухай бүрд мэдэгдэж, info@shilen.gov.mn цахим шуудангаар 580 багц мэдээллийг хүлээн авч, системд байршуулсан.		сарын 27-ны өдөр, системийн 2.0 хувилбарыг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр тус тус ашиглалтад оруулсан. Цахим хөгжил, харилцаа холбоон сайд (хуучин нэрээр)-аас Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн, 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн, 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн, 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар тус тус "Шил ажиллагаа"-ны хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байгаа талаар танилцуулга хийсэн. Тус системд мэдээлэл хариуцагч 1511 байгууллагын 1793 албан хаагч системд хандах эрхтэй болсон бөгөөд мэдээллийг хариуцагч байгууллагын нээлттэй мэдээлэл хариуцсан албан хаагч нарт системийн шинэ хувилбарт хэрхэн мэдээлэл байршуулах талаар сургалтыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна. Мөн shilen.gov.mn системийн 8 төрлийн гарын авлагыг боловсруулан, цахим хэлбэрээр байршуулж, 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 01/1142 тоот бичгээр мэдээлэл хариуцагч байгууллагуудад хүргүүлсэн. Тус яамны урсгал зардлын хөрөнгөөр нийтийн мэдээллийг нээлттэй өгөгдлийн стандартын дагуу ил болгоход иргэн шууд хяналт тавих боломжийг бүрдүүлэх цахим системийг хөгжүүлэхээр төлөвлөөд байна.	
4		3.2.4.2.Нийтийн мэдээллийг нээлттэй өгөгдлийн стандартын дагуу ил болгоход иргэн шууд хяналт тавих боломжийг бүрдүүлэх	Шалгах талбар нэмэх чиглэлээр бүртгэлийн журамд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн тоо	Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ыг баталсан.	0	"Нээлттэй мэдээллийн систем (www.shilen.gov.mn)"-ийн 2.0 хувилбарыг ашиглалтад нэвтрүүлснээр 68 нээлттэй мэдээллийг 78 шалгуур үзүүлэлтээр үнэлэх боломжтой болсон ба мэдээлэл хариуцагч 1511 байгууллагын 1793 албан хаагчид системд хандах эрх олгоод байна. Тус системд иргэний хяналт тавих боломжийг бүрдүүлж, нээлттэй мэдээллийн " shilen.gov.mn " системийн 3.0 хувилбарыг 2025 онд нэвтрүүлэхээр төлөвлөөд байна.	30

ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ

2. Олон нийтийн итгэлийг хүлээсэн авлигаас ангид нийтийн албыг бэхжүүлнэ.

2.1. Төрийн албаны хүний нөөцийн удирдлага болон томилгооны ил тод, мэргэшсэн тогтвортой байдлыг бэхжүүлнэ.

5	2.1.2.Төрийн албаны сул орон тооны талаарх мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх, сонгон шалгаруулах	2.1.2.1.Төрийн албаны сул орон тооны талаарх мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх, сонгон шалгаруулах нэгдсэн цахим систем хөгжүүлэх	Төрийн албаны сул орон тооны талаарх мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх, сонгон шалгаруулах нэгдсэн цахим системийн тоо	-	-	Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс "Шалгалтын цахим систем OPEN-EXAM"-ыг шинэчилж, 4271 байгууллагыг хамарсан, нийт 228820 албан хаагчийн мэдээлэл бүхий "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим систем" http://hh2.csc.lvg.mn/ -ийг хэрэглээнд нэвтрүүлсэн.	Үнэлэх боломжгүй
---	---	--	---	---	---	--	------------------

6	нэгдсэн цахим системийг хөгжүүлж, холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.	2.1.2.2.Төрийн албаны сул орон тооны талаарх мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх, сонгон шалгаруулах нэгдсэн цахим системийн үйл ажиллагааг хэвшүүлэх	Нэгдсэн цахим системээр зохион байгуулагдсан сонгон шалгаруулалтын хувь	-	-	"Төрийн албаны зөвлөлийн Шалгалтын цахим системд https://ta.hrm.csc.gov.mn/login тухай бүр сул орон тооны мэдээллийг байрлуулж, төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулах шалгалтыг зохион байгуулан ажилладаг. Тайлант 2024 онд цахим системээр гүйцэтгэх албан тушаалын нийт 6 сул орон тооны мэдээллийг https://hh.csc.gov.mn/?sector_id=02001022&offset=1&limit=10 нийтэлж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан."	Үнэлэх боломжгүй
---	---	--	---	---	---	---	------------------

2.5. Төрийн үйл ажиллагааны мэдээллийг цахимжуулах замаар иргэдийн мэдэх эрхийг баталгаатай эдлүүлнэ.

7	2.5.2.Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулж, хуулийн хэрэгжилтэд хоёр жил тутам үнэлгээ хийж олон нийтэд ил тод мэдээлнэ.	2.5.2.1.Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулах	Олон нийтэд нээлттэй байршуулсан мэдээллийн хувь	Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн хамтарсан А/268, А/48 дугаартай тушаалаар байгуулсан.	-	"Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн хамтарсан А/268, А/48 дугаартай тушаалаар байгуулсан. Тус яамнаас Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу нээлттэй мэдээллийг 78 шалгуур үзүүлэлтээр 7 хоног бүр Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-д заасны дагуу үнэлж, "Шилэн Индекс"-ийг зарлаж байна. Системд 2024 оны I улиралд 98, II улиралд 216, сүүлийн хагас жилд нийт 572 байгууллага тайлан ирүүлснээс 513 байгууллага үнэлэгдсэн бөгөөд дундаж үзүүлэлт 88.2%-тай байна. Үүнээс: - Төрийн захиргааны төв байгууллагын хувьд дундаж үзүүлэлт - 2024 оны 2 дугаар улиралд 9 яам дундаж хувь 90,07%, 2024 оны жилийн эцсээр 5 яам дундаж хувь 91,6%; - Төрийн захиргааны байгууллагуудын хувьд дундаж үзүүлэлт - 2024 оны 2 дугаар улирал 14 агентлаг дундаж хувь 93,07%, 2024 оны жилийн эцсээр 16 агентлаг дундаж хувь 70,9%; - Нутгийн захиргааны байгууллагуудын хувьд дундаж үзүүлэлт - 2024 оны 2 дугаар улирал 13 аймаг дундаж хувь 83.46%, 2024 оны жилийн эцсээр 14 аймаг дундаж хувь 81.42% тус тус үнэлэгдсэн. Тус яамны хувьд 97%-ийн гүйцэтгэлтэй мэдээллийг байршуулж, олон нийтийг мэдээллээр хангаж байна.	97
---	---	--	--	--	---	--	----

2.6. Салбарын эрсдэлийг оновчтой тодорхойлж, түүнд чиглэсэн арга хэмжээг үе шаттайгаар, цогц байдлаар хэрэгжүүлнэ.

8	2.6.2.Эрсдэлд суурилсан авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө	2.6.2.1.Шударга байдлын үнэлгээгээр хамгийн бага оноо авсан яам, агентлаг, нутгийн	Тухайн яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагын Шударга	-	-	Авлигатай тэмцэх газраас төрийн байгууллагуудын 2024 оны Шударга байдлын үнэлгээний судалгааг Бодлогын шийдэл ТББ-аар гүйцэтгүүлсэн бөгөөд тус байгууллагатай хамтран ажиллаж холбогдох албан хаагч, байгууллага, иргэдийг судалгаанд хамрагдахад дэмжлэг үзүүлж ажилласан.	Үнэлэх боломжгүй
---	--	--	---	---	---	---	------------------

	боловсруулж хэрэгжүүлж хэвшүүлнэ.	захиргааны байгууллагад авлигын эрсдэлийг бууруулах тусгайлсан төлөвлөгөө хэрэгжүүлэх	байдлын үнэлгээний онооны өсөлтийн хувь			Авлигатай тэмцэх газраас 2024 оны шударга байдлын үнэлгээг нийтэл ил тод зарлахаар хүлээгдэж байна.	
3. Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэн, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн бодит оролцоо, үр дүнтэй хяналтыг бэхжүүлнэ.							
3.2. Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх болон хэрэгжилтийг үнэлэхэд иргэн, иргэний нийгмийн байгууллагын бодит оролцоог хангаж иргэнд ээлтэй бодлого, шийдвэр гаргах нөхцөлийг хэвшүүлнэ.							
9	3.2.3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд заасан сонсголыг зохион байгуулахдаа иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлнэ.	3.2.3.2.Нийтийн сонсголын тухай хуульд заасан сонсголд иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх	Сонсголд оролцсон ажиглагч, оролцогчдын тооны өсөлтийн хувь	-	-	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас “Онлайн оролцоо цахим платформ”-ыг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болгосон ба уг платформ нь “Иргэд олон нийттэй харилцах 11-11” зэрэг төрийн үйлчилгээний ижил төстэй системүүдтэй давхардалгүйгээр JWT төрлийн API холболтын дагуу харилцан холбогдож ажиллах боломжтой болно. Төр, хувийн хэвшлийг холбох дээрх онлайн платформ нь хувийн хэвшлийн байгууллагуудад төрийн байгууллагуудын үйлчилгээ, мэдээллийг порталаар дамжуулан цахим хэлбэрээр авах боломжийг бүрдүүлсэн бөгөөд вэб болон хөдөлгөөнт төхөөрөмжөөр хандах боломжтой.	Үнэлэх боломжгүй
3.3. Төрийн үйл ажиллагаанд хараат бус хөндлөнгийн хяналт тавих иргэний нийгмийн байгууллагыг бэхжүүлэхэд шаардлагатай дэмжлэг бий болгоно.							
10	3.3.1.Иргэний нийгмийн байгууллагын эрх зүйн орчныг шинэчлэхдээ баримт, судалгаа, зөвлөмжийг үндэслэн тэдгээрийн бодит оролцоог хангана.	3.3.1.1.Иргэний нийгмийн байгууллагын эрх зүйн орчныг шинэчлэх хуулийн ажлын хэсэгт ажиллах иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн тоог нэмэгдүүлэх	Хуулийн ажлын хэсгийн нийт гишүүдийн тоонд эзлэх иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн эзлэх хувь	-	-	Тайлант хугацаанд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хаягжилтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байгаа ба Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд салбарын төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллийн оролцоог тухай бүрд оролцуулсан болно. Мөн салбарын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын хуулийн асуудал хариуцсан албан хаагчдыг хамруулан нэгдсэн уулзалтыг зохион байгуулсан бөгөөд уг уулзалтад тус яамны холбогдох албан хаагчид оролцож салбарын хууль тогтоомжийн шинэчлэлийн талаар санал солилцож, хэлэлцүүлэг өрнүүлсэн. Салбараас “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д дараах хуулийн төслүүдийг боловсруулан батлуулахаар тусгаад байна:	Үнэлэх боломжгүй

						1. Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Өргөн нэвтрүүлгийн тухай; 2. Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 3. Шуудангийн тухай (Шинэчилсэн найруулга); 4. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийн тухай (Анхдагч хууль).	
11		3.3.1.4.Авлигатай тэмцэх зорилго бүхий иргэний нийгмийн байгууллагын сүлжээ, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилтийн өсөлтийн хувь	-	-	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас хариуцан хэрэгжүүлэх 4, бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх 16 арга хэмжээний хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллаж байна.	Үнэлэх боломжгүй
12		3.3.1.5."Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагад дэмжлэг үзүүлэх, олон нийтийн хяналт хэрэгжүүлэх этгээдийг чадавхжуулах	Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн Олон нийтийн хяналтын үйл ажиллагааны тоо	-	-	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг мөрдөж ажиллахыг төрийн бүх шатны байгууллагын дарга нарт даалгасны дагуу журмын хэрэгжилтийг хангах хүрээнд уг ажлыг хөндлөнгийн хараат бус этгээдээр гүйцэтгүүлэхээр тус яамны 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, холбогдох гэрээг "Судлаач соно бодлого судалгааны төв" НҮТББ-тай байгуулан ажилласан. Үйлчилгээ үзүүлэгч нь журмын 2.1-т заасан чиглэл, үйл ажиллагааны дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон түүний харьяа байгууллагууд болох Үндэсний дата төв УТҮГ, Радио, телевизийн үндэсний сүлжээ УТҮГ, И-Монгол академи УТҮГ, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албан дээр 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд ажиллаж, холбогдох дүгнэлт, зөвлөмжийг гарган хүлээлгэн өгсөн болно. Гэрээний хэрэгжилтийг хүлээн авах хүрээнд 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр тус яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга болон харьяа байгууллагуудын захиргаа удирдлагын нэгжийн дарга нар болон Эрх бүхий албан тушаалтны чиг үүргийг хариуцан ажиллаж байгаа албан хаагчдад тайлан танилцуулах уулзалтыг зохион байгуулсан.	Үнэлэх боломжгүй
6. Авлигын гэмт хэргийн шинжийг хийдэлгүй тодорхойлох, хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.							
6.4. Шаардлагатай бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.							
13	6.4.11.Төрийн бүх шатны байгууллага, төрийн болон	6.4.11.1.Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний	-	-	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг 5 зорилтын хүрээнд 11 арга хэмжээг хэрэгжүүлж, жилийн эцсээр гүйцэтгэлийг 85 хувиар үнэлэн	61.88

	орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлигатай тэмцэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг сайжруулна.	хэрэгжилтийг бүрэн хангах	хэрэгжилтийн хувь			хүргүүлсэн бөгөөд Авлигатай тэмцэх газраас үнэлгээний хувийг бууруулан 61,88 хувь болгосон. Удирдлагын санаачилгаар хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд “Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон харьяа байгууллагын үйл ажиллагаанд авлигын эрсдэлийн үнэлгээ хийх” ажлыг хөндлөнгийн этгээдээр төлбөртэй гүйцэтгүүлэхээр яамны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулан хэрэгжүүлсэн.	
--	---	---------------------------	-------------------	--	--	---	--

7. Төсөв, санхүү, аудитын хяналтыг сайжруулан, худалдан авах ажиллагааны авлигын эрсдэлийг бууруулна.

7.1. Төсвийн төлөвлөлтийн тогтолцоог урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулж, тэгш хүртээмжтэй, нээлттэй, олон нийтийн оролцоог хангах замаар бэхжүүлнэ.

14	7.1.2.Төсвийн тухай хуульд төсвийн орлого, зарлагын мэдээллийг төсөв захирагчдаар нийтлэхээс гадна эдийн засгийн болон зориулалтын ангиллаар тооцон тусгана.	7.1.2.1.Төсвийн орлого, зарлагын мэдээллийг эдийн засгийн болон зориулалтын ангиллаар харуулах тусгах	Төсвийн нээлттэй байдлын олон улсын судалгааны Жилийн төсвийн төслийн баримт бичгийн агуулгын үзүүлэлтийн оноо	-	-	Төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн шууд захирагчийн мэдээллийг шилэн дансанд хуулийн хугацаанд нийтэлж байна. https://shilendans.gov.mn/organization/4097?ry=2025&group=6 1. Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр) мэдээг хуулийн хугацаанд шилэн дансны цахим системд тогтмол нийтэлж байна. https://shilendans.gov.mn/organization/4097?ry=2024&group=6 2.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналд нийт 142 тэрбум төгрөгийн 30 төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгө оруулалтын цахим системээр төлөвлөж, ач холбогдол, олон нийтийн санал асуулгын үр дүнгээр эрэмбэлж, цахим системээр хуулийн хугацаанд хүргүүлсэн. МУЗГ-ын 2024 оны 93 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах журам”-д заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төслийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны https://mddc.gov.mn/mn/ цахим хуудсанд ил тод байршуулж, олон нийтэд хэлэлцүүлсэн үр дүнг нэгтгэн 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 01/130 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн шууд захирагчийн мэдээллийг шилэн дансны Дэлгэрэнгүй мэдээлэл хэсэгт ил тод, тодорхой мэдээлсэн. https://shilendans.gov.mn/organization/4097?ry=2025&group=6	Үнэлэх боломжгүй
----	--	---	--	---	---	---	------------------

15		7.1.2.2.Төсвийн тухай хууль дахь төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн шууд захирагч гэсэн ерөнхий мэдээллийг байгууллага тус бүрээр албан тушаал, нэрээр ил тод тодорхой болгох нэр тус бүрээр ил тод, тодорхой мэдээлэх	Төсвийн нээлттэй байдлын олон улсын судалгааны Жилийн төсвийн төслийн баримт бичгийн агуулгын үзүүлэлтийн оноо	-	-	Төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн шууд захирагчийн мэдээллийг шилэн дансанд хуулийн хугацаанд нийтэлж байна. https://shilendans.gov.mn/organization/4097?ry=2025&group=6	Үнэлэх боломжгүй
----	--	---	--	---	---	--	------------------

7.3. Засгийн газрын өр, тусгай сан, гадаадын зээл, тусламжийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, менежментийг сайжруулах чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.

16	7.3.4.Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын сангийн төсөв, хөрөнгийн удирдлага ил тод, хараат бус, олон нийтийн хяналтад байх тогтолцоог бүрдүүлж, холбогдох яам, агентлаг, үндэсний зөвлөлийн эрх хэмжээ, хяналт, хариуцлагыг нэмэгдүүлнэ.	7.3.4.1.Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын сангийн төсөв, хөрөнгийн удирдлага ил тод, хараат бус, олон нийтийн хяналтад байх тогтолцоог бүрдүүлэх, холбогдох яам, агентлаг, үндэсний зөвлөлийн эрх хэмжээ, хяналт, хариуцлагыг нэмэгдүүлэх	Нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль тогтоомжийн тоо	-	-	Тус яамны дэргэд Монгол Улсын Засгийн газрын тусгай сангууд болох Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан, Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан тус тус ажиллаж байна. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/61 дүгээр тушаалаар Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, цаашид авч хэрэгжүүлэх санал, зөвлөмж боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Тус ажлын хэсгээс "Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын журам"-д нэмэлт өөрчлөлт хийх эсэхэд санал, зөвлөмж гаргаж, сангийн үйл ажиллагаатай холбоотой мөрдөж байгаа хууль, дүрэм, журмыг судлан санал танилцуулахаар хүлээгдэж байна.	Үнэлэх боломжгүй
----	--	--	---	---	---	---	------------------

9. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг олон нийтийн оролцоонд тулгуурлан цогц байдлаар зохион байгуулна.

9.1. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг шинжлэх ухаан, технологийн дэвшил, судалгаанд суурилсан байдлаар төлөвлөн хэрэгжүүлнэ.

17	9.1.4.Авлигаас урьдчилан сэргийлэх, соён	9.1.4.1.Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл	Нэвтрүүлсэн мэдээлэл, харилцаа холбооны	-	-	"Монгол Улс болон Дэлхийн банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциаци нарын хооронд 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр байгуулсан "Ухаалаг засаг 2 төсөл"-ийн Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай" Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх хүрээнд	Үнэлэх боломжгүй
----	--	--	---	---	---	--	------------------

	гэгээрүүлэх үйл ажиллагаанд мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, цахим платформ судалж, нэвтрүүлнэ.	ажиллагаанд мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, цахим платформ нэвтрүүлэх	дэвшилтэт технологи, цахим платформын тоо			"2.1.4.1.Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн систем хөгжүүлэх" төслийн ажил гүйцэтгэгчийг шалгаруулан ажиллаж байгаа бөгөөд урилгыг олон нийтэд 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр нээлттэй зарлаж, 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр тендерийг хүлээн авч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан ба гэрээний гүйцэтгэгчээр Ай ти зон ХХК-ийг шалгаруулан холбогдох гэрээг баталгаажуулах ажлыг хийж байна.	
9.2. Олон нийтийг авлигаас ангид байлгах, нийгмийн ёс суртахууныг дээшлүүлэх зорилгоор үндэсний контентыг бүтээж, түгээнэ.							
18	9.2.2.Авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэхэд соёл, урлаг, спорт, хэвлэл мэдээллийн оролцоог нэмэгдүүлж, мэдээлэл солилцох сувгийг хөгжүүлнэ.	9.2.2.1.Авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэхэд соёл, урлаг, спорт, хэвлэл мэдээллийн оролцоог нэмэгдүүлж, мэдээлэл солилцох сувгийг хөгжүүлэх	Авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаанд оролцсон соёл, урлаг, спорт, хэвлэл мэдээллийн салбарт хамаарах хуулийн этгээд, хувь хүний тоо	-	-	Авлигын эсрэг 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 1 арга хэмжээг харьяа байгууллагуудын хамт хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.	Үнэлэх боломжгүй
9.4. Хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бууруулах арга замаар ёс зүйн төлөвшлийг дэмжинэ.							
19	9.4.2 Хүүхдэд үл тохирох контентын хязгаарлалтын түвшинд стандарт тогтоох холбогдох зохицуулалтыг бий болгоно.	9.4.2.1.Хүүхдэд үл тохирох контентын хязгаарлалт бий болгож хэрэгжүүлэх	Нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль тогтоомжийн тоо	-	-	"Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалтад "телевизийн үйлчилгээ эрхлэгч нь хүүхэд залуусын сэтгэхүйд сөргөөр нөлөөлөх, хүчирхийлэл, садар самууныг сурталчлах, гэмт хэргийн үйлдлийг нарийвчлан зааварчилсан, хар тамхи, сэтгэхүйд нөлөөлөх эм бэлдмэл бэлтгэн боловсруулах, хэрэглэх зэрэг бүтээлийг бэлтгэн дамжуулахыг хориглоно" гэж заасны дагуу өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч, вэб сайтын үйлчилгээ эрхлэгч, интернэтийн үйлчилгээ эрхлэгч болон олон судаг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид тавигдах нөхцөл шаардлагуудад хүүхдэд үл тохирох контентын хязгаарлалт бий болгох зохицуулалтыг тус тус тусгасан. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд салбарын чиг үүргийн хүрээнд холбогдох зохицуулалтын саналыг тухай бүр хүргүүлж ажилласан ба хуулийн 25 дугаар зүйлд "Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгаалал"-тай холбоотой нийт 13 зохицуулалт туссан. Уг хууль 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд уг хуулийн хүрээнд "Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн	70

						цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах журам"-ын төсөл, "Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам"-ын төслийг Хууль зүй дотоод хэргийн яам болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран боловсруулан олон нийтийн хэлэлцүүлгийг 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан.	
						"Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах журам"-ын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлээд байна.	
9.5. Төрийн албанд ёс зүйн шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж ажилд авах соёлыг төлөвшүүлж, тогтолцоог бүрдүүлнэ.							
20	9.5.2. Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчилна.	9.5.2.1.Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлах	Зохион байгуулсан арга хэмжээ	-	-	Авлигатай тэмцэх газраас гаргасан мэдээ, мэдээллийг нийтийн мэдээллийн дэмжих системийн нэг төрөл болох мэдэгдэл хүргэх системээр дамжуулан иргэдэд түгээх боломжтой бөгөөд энэ талаар Авлигатай тэмцэх газартай хамтран ажиллахаар төлөвлөөд байна.	Үнэлэх боломжгүй
						Нийт гүйцэтгэл	71.66%